MERIT
A CESO AND WUSC PROGRAM

Global Affairs Canada
Affaires mondiales Canada

Төслийн загвар (заавар)

Эх сурвалж: Гарын авлагын Бүлэг 6-ын 49-65-р нүүр

Агуулга

Төсөл

Олон улсын төслийн удирдлагын тэргүүлэх зарчим (PMBoK)

Тэгш байдал, тэгш эрхийг тогтооход чиглэсэн тусгай арга хэмжээ

Үр дүн ба зорилтууд

Төслийн гол үйл явдлын товчоон (цаглабар)

Төлөвлөгөө, нөөц ба менежмент

Шалгуур үзүүлэлт, зорилтот түвшин

Төсөл

- Төсөл нь тодорхой хамрах хүрээ, нөөц, тогтоосон эхлэх, дуусах хугацаатай арга хэмжээ юм.
- Энэ нь өдөр тутам давтагддаг үйл ажиллагаа биш, харин тодорхой зорилгод хүрэхэд зориулагдсан тодорхой үйл ажиллагааны цогц юм.
- Төслийг байгууллагад хэрэгтэй зүйлсийг суралцаж нэвтрүүлэхийн тулд тодорхой хугацаанд, тодорхой төсөвт багтаан мэргэжлийн түвшинд удирдах ёстой.

Олон улсын төслийн удирдлагын тэргүүлэх зарчим (PMBoK)

- PMBOK гэдэг нь олон улсын төслийн удирдлагын талбарт хүлээн зөвшөөрөгдсөн үйл явц, шилдэг туршлагууд, нэр томьёо, заавар зөвлөмжийг бүхэлд нь нэгтгэн эмхэтгэсэн баримт бичиг юм.
- Гишүүд нь улс орнуудын төслийн удирдлагын мэргэжлийн холбоод байдаг ашгийн бус байгууллага болох Олон улсын төслийн удирдлагын институт (PMI)-ээс уг хэвлэлийг эрхлэн гаргадаг.

Тэгш байдал, тэгш эрхийг тогтооход чиглэсэн тусгай арга хэмжээ

- Тэгш байдал, тэгш эрхийг тогтооход чиглэсэн тусгай арга хэмжээ гэдэг нь зорилтот бүлгүүдийн хүн амд бүхий л түвшинд тэгш хандаж, тэгш боломж эдлүүлж, нийгэм болоод ажиллах хүчинд тэгш төлөөлөл, оролцоотой байлгахад чиглэсэн аливаа үйл ажиллагаа юм.

Үр дүн

- Үр дүн гэж төслийн нэг хэсэг, эсвэл төслийн тодорхой нэг бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа, эсвэл үйл явцын үр дүнд бий болох тодорхой гарц буюу эцсийн бүтээгдэхүүн юм.
- Эдгээр үр дүн нь тодорхой өөрчлөлт (тухайлбал, сайжруулсан үйл явц, байгууллагын бүтцийн өөрчлөлт, эсвэл бэлтгэгдсэн хүний нөөц гэх мэт), эсвэл бодит зүйлс (тухайлбал, баримт бичиг гэх мэт) байна.

Зорилт

- Төслийн зорилтууд нийлж ерөнхий зорилгын төлөө үйлчилдэг. Эдгээр нь таны төслийн хүрээнд хүрэхийг хүсч буй зорилтууд гэсэн үг.
- Төслийн зорилтуудыг тодорхой заасан байх ёстой.
- Төслийн зорилтууд нь хэмжигдэхүйц байх ёстой бөгөөд төслийн амжилтыг үнэлэхэд ашиглагдах гүйцэтгэлийн голлох шалгуур (KPI) үзүүлэлтийг агуулсан байх ёстой.
- Шалгуур үзүүлэлт нь төсөв, чанар, хугацааг голчлон авч үздэг.

Төслийн гол үйл явдлын товчоон (цаглабар)

- Энэ нь төслийн хугацааны туршид төслийн удирдлагын тодорхой чухал үйл явдал, тохиолыг тэмдэглэхэд хэрэглэдэг арга хэрэгсэл юм. Энэ нь төслийн эхлэх болон дуусах огноо зэрэг гол гол хугацааг илтгээд зогсохгүй, хөндлөнгийн хяналт хийлгэх буюу санал дүгнэлтийг нь авах, төсвийн шалгалт хийх хугацаа зэргийг заадгаараа онцлог.

Төлөвлөгөө

- Төслийн төлөвлөлт нь төслийн менежментийн үйл явцын нэг үе шат бөгөөд төслийг амжилттай хэрэгжүүлэхийн тулд зохих баримтжуулалтыг хийдэг.
- Баримтжуулалт нь төслийг тодорхойлох, бэлтгэх, нэгтгэх, нэмэлт төлөвлөгөөг боловсруулахад шаардлагатай бүхий л үйл ажиллагааг агуулна.
- Төслийн төлөвлөгөөнд төслийг хэрхэн хэрэгжүүлж, хянаж, удирдаж, хаах талаар тодорхой тусгана.

Нөөц

- Төслийн менежментэд төслийн зорилтуудыг биелүүлэхэд тодорхой нөөц шаардагддаг. Тэдгээрт төслийн үйл ажиллагааг гүйцэтгэхэд шаардлагатай хүн хүч, тоног төхөөрөмж, барилга байгууламж, санхүүжилт эсвэл өөр бусад чадвартай холбоотой зүйлс (ажиллах хүчнээс бусад) орно.

Төслийн менежмент

- Төслийн менежмент гэдэг нь тодорхой зорилгод, тогтоосон хугацаанд амжилттай хүрэх шалгуур үзүүлэлтийг хангахын тулд тухайн багийн ажлыг эхлүүлэх, төлөвлөх, хэрэгжүүлэх, хянах, хаах арга ажиллагаа юм.

Шалгуур үзүүлэлт

- Шалгуур үзүүлэлт бол хөтөлбөрийн нэг хэсгийг хэмжиж, хүссэн үр дүндээ хүрэхэд хэр ойр байгааг илэрхийлэх үзүүлэлт юм. Шалгуур үзүүлэлт нь төслийн явцыг үнэлэх бодит, хэмжигдэхүйц хэмжүүр болдог. Төслийг эхлэхээс өмнө шалгуур үзүүлэлтийг тодорхойлох нь зүйтэй бөгөөд ингэснээр төсөл хэрэгжүүлнэ гэж амласан зүйлээ хийж байгаа эсэхийг хянах, үнэлэх боломжийг бидэнд олгодог.

MERIT
A CESO AND WUSC PROGRAM

Global Affairs Canada
Affaires mondiales Canada

Баярлалаа.